



1.9 Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдон ажиллаж байсан хүмүүсийг 65 нас хүртэл нь Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн туслах зэргийг байнгын гишүүнээр ажиллуулах, түүнчлэн тодорхой асуудлаар судалгаа хийх, танилцуулга болгох, зөвлөмж гаргах, үндэсний болон олон улсын хэмжээний зурал зохион байгуулах, тэдгэрт оролцох, дэргэдээ ажлын аппарат байгуулж ажиллуулах зэрэгт зориулж шаардагдах зардлыг улсын төлөвөөс гарган санхүүжүүлж байх асуудлыг хуульчлан баталгаажуулахаар ажиллана.

ХОЁР ЗАСГИЙН ГАЗРЫН ТҮВШИНД ХАМТРАН АЖИЛЛАХ ТҮХАЙ

2.1 УИХ-ын гишүүн Засгийн газрын гишүүнээр хэвсгэн ажиллах асуудлыг **хөвгөөрлэх тухай хуулийг батлан гаргахдаа хамтарсан Засгийн газрыг оцруулахгүй байх байр суурийг баримтлана.**

2.2 Засгийн газарт бүтцийн өөрчлөлт хийх болон аль нэг сайдыг ротацийн журмаар болон бусад шалтгаанаар сольж салгах талаар тухайн намын гаргасан боловсон хүчний бодлогын саналд нөгөө тал хүндэтгэлтэй хандаж, хамтарч буй намын хүний нөөцийн талаар гаргасан аливаа шийдвэрт хуульчлан оролцохгүй байх, хувь хүмүүсийн явцуу зох ашигт баригдахгүй байх зэрэг зарчмыг баримтлан нөгөө нам нь тусгай дэмжиж ажиллана. Өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдлыг сайжруулах, яамдын үйл ажиллагааг давхцуулахгүй байх зэрэг зорилго, зарчмыг нийцүүлэн МАХН-ын хүний нөөцийн бодлогын дагуу аль нэг яамны оронд өөр яамыг удирдах санал гаргавал тухай бүр зөвлөлдөн зөвшилцөж шийдвэрлэнэ.

2.3 АН болон МАХН нь улс орны хэмжээний томоохон бүтээн байгуулалтын төслүүдийг гардан хариуцах, тэдгээрийн хэрэгжүүлтийг зохицуулах, гадаадын хөрөнгө оруулалтыг татаж оруулах талаар санаачлага гарган хамтран ажиллана.

ГУРАВ. БУСАД

3.1 МАХН-ын дарга, Монгол Улсын 3 дахь Ерөнхийлөгч Н. Энхбаярыг олон улсын байгууллагад хариуцлагатай албан тушаалд, тухайлбал НҮБ-ын оролч дарга, НҮБ-ын харьяа байгууллагуудын дарга зэрэг албан тушаалуудад томилуулах талаар Гадаад харилцааны яам албан ёсны санал тавьж ажиллана.

- 3.2 Шударга төр засаг, шударга шүүх засаглалыг тогтоох талаар Та санаачлага гарган идэвхтэй хамтран ажиллах, ялангуяа МАХН-ын дарга Н.Энхбаярын болон түүний гэр бүлийн гишүүд, хамтран зүтгэгчдийг мөрдөж мөшгиж буй асуудлыг Ардчилсан нам судлан тодруулж, хууль бус үйл ажиллагааг зогсоох талаар тодорхой арга хэмжээ авахаар тохиролцов.
- 3.3 Түншлэлийн гэрээнд зааснаас бусад аливаа асуудал шинээр гарч ирвэл тухайн үед ажил хэргийн журмаар санал бодлоо солилцож, байр сууриа нэгтгэн хэрэгжүүлж ажиллахаар тогтов.
- 3.4 Энэхүү гэрээнд Талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болох бөгөөд 2020 оныг дуустал хүчинтэй байна.

2014 оны 4-р сарын 10-ны өдөр

Улаанбаатар хот

ТҮНШЛЭЛИЙН ГЭРЭЭГ БАЙГУУЛСАН:

МАХН-ЫГ ТӨЛӨӨЛЖ:

МАХН-ЫН ДАРГА Н.ЭНХБАЯР

МАХН-ЫН ДЭД ДАРГА

Д.ТЭРБИШДАГВА

УИХ-ЫН ДЭД ДАРГА Л.ЦОГ

МАХН-ЫН ЕРӨНХИЙ НАРИЙН

Бичгийн дарга

АРДЧИЛСАН НАМЫГ ТӨЛӨӨЛЖ:

АРДЧИЛСАН НАМЫН ДАРГА Н.АЛТАНХУЯГ

УИХ-ЫН ДАРГА З.ЭНХБОЛД

УИХ ДАХЬ АРДЧИЛСАН НАМЫН БҮЛГИЙН
ДАРГА Д. ЭРДЭНЭБАТ

УИХ-ЫН ГИШҮҮН, МОНГОЛ УЛСЫН САЙ,
ЗГХЭГ-ЫН ДАРГА Ч. САЙХАНБИЛЭГ

~~МАХН 2020 он хүртэл МАН-ын саналыг хувааж АН-д туслаад, хариуд нь Н.Энхбаярыг НҮБ-д томилуулах~~